

## Түүх 2 : Давид ба Голиат

Библийн эшлэл  
[1Самуел 17:45]

Давид филист хүнд – Чи илд, бамбай, жад барьж над уруу ирж байгаа бол харин би чиний доромжилсон Израилийн бүх цэргийн Бурхан, түг түмдийн ЭЗЭНий нэрээр чам уруу ирж байна.

Давид гэдэг хоньчин хүү байв.

Тэрээр хонин сүргээ маш сайн хариулдаг төдийгүй ятга хөгжмөөр чадварлаг хөгжимдөж Бурханыг магтдаг нэгэн байв.

Давидын ятга хөгжим сайн тоглож, Бурханыг магтдаг тухай яриа хүмүүсийн дунд тархаж эхлэв.

Давид магтан дуу маш сайхан дуулаад зогсохгүй сайн залбирдаг байлаа.

Давид Бурхан үргэлж өөртэй нь хамт байдаг гэдэгт итгэдэг байлаа.

Давидыг хонио хариулж байхад хоньд уруу нь араатан амьтад их дайрдаг байжээ.

Маш том арслан, баавгайтай таарна гэдэг бяцхан Давидад аймшигтай зүйл байлаа.

Тэгээд Давид Бурханаас залбиран гүйжээ.

Ийнхүү Давид араатан амьтаас хонио хамгаалахын тулд чулуу дүүгүүрдэх бэлтгэл хийж эхлэв.

Хонин сүрэг рүү нь дайрч байгаад Давидын дүүгүүрийн чулуунд оногдсон арслан, амандаа зуусан хургыг хаяад айн зүгтжээ.

Нэгэн өдөр Израиль улс Филистчүүдтэй айхтар том тулааныг хийх болжээ.

Аавынхаа захиасаар ах нарыгаа эргэхээр дайны талбарт ирсэн Давид, Филистийн ирүүл цэрэг Голиат Бурханы ард түмнийг доромжилж байхыг харжээ.

Давид хүмүүст яаж филистчүүд Бурханы хүмүүсийг доромжилж чадаж байна гэж хэлэв.

Зарим хүмүүс нь тэр үгийг сонсоод Саул хаанд дамжуулан хэлэв. Саул хаан Давидыг дуудуулав.

Саул хаан бяцхан Давидтай ярилцсаны дараа дайнд оролцох зөвшөөрлийг олгов.

Давид бүх зүйл дээр Бурхан өөрт нь тусална гэдэгт итгэж байлаа. Бурханыг доромжлогч Филист цэрэгтэй тулалдахад ч гэсэн Бурханы тусламжаар дийлж чадна гэж итгэж байлаа.

Давид аварга биетэй Голиаттай тулалдахаар явахдаа хонио хамгаалахад хэрэглэдэг саваа мод болон дүүгүүр, таван ширхэг мөлгөр чулууг авч явжээ.



Давид болон Голиат нар өөр өөрсдийн тулалдааны талбарт гарч Голиат түүнийг хараад чанга дуугаар шоолжээ.

Тэгсэн ч гэсэн Давид айхгүй байлаа.

Давид Голиат руу гүйн очоод дүүгүүрээ дүүгүүрдэн Голиатын духыг оножээ.

Филист цэрэг Голиат нь асар хурдтай нисэн ирж байгаа чулуунаас бултаж чадаагүй билээ. Харин чулуу түүний духанд нь онож газарт пид хийн ухаан алдан унажээ.

Давидын гарт илд байхгүй байсан тул тэр Голиатын илдийг сугалан толгойг нь тасалжээ.

Үүнийг харсан Филист цэргүүд маш ихэд айн зугтан оджээ. Ингээд тэр өдөр Израильчууд том дайнд ялалт байгуулав.

Давид хонио хариулахдаа, Бурханы тусламжинд найддаг шигээ энэ тулаанд ч гэсэн Бурханд найдах үед тэр ялалт байгуулж чаджээ.

Хонин сүргээ хамгаалахын тулд сурсан арга нь хожим Израилийг аюулт дайснаас аврах арга болон ашиглагджээ.

● Дараах эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (1Самуел 17:45)

ЭЗЭНий нэрээр чам уруу ирж байна





